

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

#### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 17

Хуралдаан 2013 оны тавдугаар сарын 30-ны өдрийн 10 цаг 30 минутад эхэлж, 11цаг 20 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 20 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны зарим газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p> <ul style="list-style-type: none"><li>- Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга</li><li>- Хүнд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга</li><li>- Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга</li></ul>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Цэвээнравдангийн Баярмааг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Мягмарсүрэнгийн Баянмөнхийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Дамдинсүрэнгийн Чулуунбат, Наянтайн Ганибал нарыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.</p> <p>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан иргэдээс Цэвээнравдангийн Баярмааг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Мягмарсүрэнгийн Баянмөнхийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хүнд үйлдвэрийн</p>

		<p>бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Наянтайн Ганибалыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Золжаргалд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Санхүүгийн зохицуулах хорооны Тамгын газрын Санхүүгийн боловсрол, сургалт сурталчилгааны хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Санхүүгийн зохицуулах хорооны Тамгын газрын Санхүүгийн боловсрол, сургалт сурталчилгааны хэлтсийн даргын албан тушаалд Сүхбаатарын Энхцэцэгийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Х.Бум-Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалын сайд С.Эрдэнийн 2013 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 1/1860, Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалын яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга Б.Отгонжаргалын 2013.05.23-ны өдрийн 08 тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор Монгол Улсын Засгийн хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн</p>

		<p>даатгалын ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 6 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулахаар шийдвэрлэв.</p>
4	<p>Нийслэлд зохион байгуулсан Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, хамгийн өндөр оноо авсан иргэдийг өрсөлдсөн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 56 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 05 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Нийслэлд зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Нийслэлд 2013 оны 05 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 136 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1 дүгээр хавсралтаар батлах.</li> <li>2. Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 7 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 2 дугаар хавсралтаар батлах.</li> <li>3. Энэхүү тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан нэр бүхий 7 иргэнийг “Нийтийн албанд</li> </ol>

		<p>нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулахыг Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	<p>Дорноговь, Өвөрхангай аймагт зохион байгуулсан Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, хамгийн өндөр оноо авсан иргэдийг өрсөлдсөн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 56 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Дорноговь, Өвөрхангай аймагт зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Дорноговь, Өвөрхангай аймагт 2013 оны 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 74 иргэн, үүнээс 38 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 36 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1, 2, 3, 4 дүгээр хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын</p>

		<p>төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 20 иргэнийг, "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 14 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 5, 6, 7, 8 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын 5, 6, 7, 8 дугаар хавсралтаар баталсан нэр бүхий 14 иргэнийг "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулахыг Дорноговь, Өвөрхангай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Төрийн жинхэнэ албан тушаалын зарлагдсан сул орон тоонд хүн бүртгүүлэхгүй байгаад дүн шинжилгээ хийж танилцуулах болон энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	<p>Төв аймагт ажилласан Ажлын хэсгийн тайлан</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төв аймагт ажилласан Ажлын хэсгийн танилцуулга</li> <li>- Төв аймагт зохион байгуулсан Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох</li> </ul>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам"-ын 56 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Төв аймагт зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх</p>

<p>иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, хамгийн өндөр оноо авсан иргэдийг өрсөлдсөн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай</p>	<p>тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төв аймагт 2013 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 94 иргэн, үүнээс 47 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 47 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1, 2 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 17 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 8 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 3, 4 дүгээр хавсралтаар тус тус батлах</p> <p>3. Энэхүү тогтоолын 3, 4 дүгээр хавсралтаар баталсан нэр бүхий 25 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулахыг Төв аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--

## **ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**